

жинд үндсэн гурван ишний зөв зохицолтыг алдагдуулахгүйгээр нэмж цэцэг суулгаж болно.

Цэцгээ шилж сонгохоосоо өмнө ваар, савныхаа хэлбэр, хэмжээг зөв тогтоох нь хамгийн чухал, учир нь цэцгийн зохиомж нь савныхаа хэмжээ, өргөн, гүнзгийгээс бүрэн хамаарна.

Икэбанаг хийхдээ, бэлдсэн цэцгээ баруун гар талдаа, цэцгийнхээ ваарыг цэцэгнээсээ 60 см орчим зайтай байрлуулна. Учир нь зохиомж хийх үед нийт цэцгийнхээ байрлалыг сайн харахын тулд ваараа зайтай, нүднийхээ төвшнөөс яльгүй дээр байрлуулах нь тохиромжтой байдаг. Икэбанад хэрэглэх материалаа бэлэн болгосны дараа иш, навчнуудыг тайрч огтлох ажилд орж болно. Уран сайхны цэцгийн зохиомж хийж эхлэхээс өмнө цэцгийн зарим хэрэггүй иш, навч зэргийг тайрч огтолно, шаардлагатай бол зохиомж хийж байх үедээ зарим нэгэн иш, навчийг мөн хайчилж болно. Цэцгийг үхүүлэхгүй удаан байлгахын тулд физик буюу химийн арга хэрэглэдэг. Хамгийн энгийн бөгөөд хялбар арга бол «мизукири», өөрөөр хэлбэл, ишийг тайрахдаа усан дотор нь хайчлах арга юм. Үүний тулд тайрсан ишнийхээ өнцөгт агаар оруулахгүй байхыг хичээх хэрэгтэй. Агаар орсон тохиолдолд уг ишийг дахин усанд суулгахад ус сорж амьсгалах чадвараа тодорхой хэмжээгээр алддаг тул цэцэг амархан үхнэ. Химийн арга гэвэл, давсны буюу хүхрийн хүчлийг бага хэмжээний усанд найруулж цэцгийг сэргээж амилуулна. Химийн хамгийн хялбар арга бол ишний өнцөгт бага хэмжээний давс түрхэх явдал. Гэвч «мизукири» бол хамгийн үр ашигтай дэлгэрсэн арга юм.

Японы икэбана цэцгийн урлаг нь маш олон сургууль урсгалтай. Нэг сургуульд тогтсон дүрэм нөгөө сургуульд тэр болгон хэрэглэгддэггүй байх жишээтэй. Сургууль болгон өөрийн гэсэн үзэл бодол тогтолцоотой байдаг. Харин икэбана урлагийн гол үндсэн зарчмуудыг бүх сургууль нарийн чанд сахин хамгаалдаг.

Одоо үед Японд икэбанагийн 3000 орчим сургууль, урсгал байдаг, тэдгээрийн дотроос Икэнобо сургууль нь хамгийн эртнийх нь (XV зуун) болно. XX зууны эхээр Охара Унсин гэдэг хүн Охара сургуулийг бий болгож, 1927 онд Тэсигавара Софу нь икэбанагийн Согэцу сургуулийг байгуулжээ. Энэ гурван сургууль Японд одоо байгаа сургуулиудаас хамгийн том нь бөгөөд нийт сая гаруй гишүүнтэй.

Японы икэбана цэцгийн урлагийн зорилго бол цэцэг, шаазан ваар зэрэг зүйлээр байгалийн гоо сайхныг илтгэн харуулахаас гадна өөрөө өөрийгөө илэрхийлэх нэг арга юм. Янз бүрийн хүмүүс нэг ижил материалыг ашиглан, өөр өөрийн үзэл санааг икэбанагаар илэрхийлж гаргаж чадна. Байгалийг гоо сайхны шавхаршгүй эрдэнэс гэж үзэн байгальтай харьцах авьяас чадвараа хэдэн зуун жил, үеэс үед дамжуулан ирсэн ард түмэн икэбанаг зохиосон билээ.

## **ИЛИ КАЗАХЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ТОЙРОГ**

**М. Хурметхан**

БНХАУ-ын Синьцзян-Уйгурын Өөртөө засах орны (СУӨЗО) Или казахын өөртөө засах тойрог нь тус орны баруун хойд талд байдаг засаг захиргааны нэгж юм. Тус тойрог нь зүүн хойт талаараа манай улсын Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймагтай, баруун талаараа КазССР-ийн хэд хэдэн мужтэй хил залган оршдог байна. Или казахын өөртөө засах тойргийн хилийн шугамын нийт урт нь 2322 км, нутаг дэвсгэрийн хэмжээ нь 350 мянган км<sup>2</sup> бөгөөд СУӨЗО-ны бүх нутаг дэвсгэрийн  $\frac{1}{5}$ -тэй тэнцэнэ. Тус тойрог нь Или, Тарбагатай, Алтай гэсэн гурван районд хуваагдан, 20 хошуу, Чапчал-шивэй, Ховугсайр монголын

өөртөө засах хошуугаас бүрдэнэ. Кульджа, Куйтунь, Тарбагатай, Алтай гэсэн хошууны хэмжээний 4 хоттой. Тойргийн засаг захиргааны төв нь Кульджа хот. 1975 оноос тойргийн төв нь Куйтунь хотод төвлөрч байгаад дахин Кульджа хотод шилжсэн юм. Тус тойрогт 1985 оны байдлаар 13 үндэстэн ястны төлөөлөгчдөөс бүрдсэн 3 сая 23 мянган хүн ам аж төрж байв.

Тойргийн уугуул хүн ам бол казах, монгол, уйгурууд бөгөөд сүүлийн 30-аад жилд хятад иргэд олноор шилжин ирж суурьшсаны улмаас хүн амын олонхи болжээ. Тухайлбал, 1985 онд тойргийн хүн амын дотор казах 26%, уйгур 16%, хятад 46% болж бусад үндэстэн ястан 4,4 % байснаас тодорхой харагдаж байна. Эндхийн казах, уйгур, хотон, киргиз, узбек, татар, тажик, салар, дунган хүмүүс нь лалын шашин шүтдэг байна. Тус өөртөө засах тойргийн хятад биш ард түмнүүд өөрсдийн хэл, бичиг үсгийг хэрэглэж байна.

Или казахын өөртө засах тойргийн нутаг дэвсгэр нь байгалийн баялагаар арвин юм. Энд нефть, уран, зэс, алт, чулуун нүүрс, төмөр, хөнгөн цагаан, хар тугалга, цайр, гялтагануур, болор, үнэт чулуу зэрэг 110 гаруй төрлийн баялаг илэрсэн байна. Геологи хайгуулын ажил явуулсан байдлаас үзэхэд нүүрсний нөөц хэмжээ 50 миллиард тонноос давж чанарын хувьд сайн, үнсжилт бага, хүхэрийн хэмжээ доогуур, газрын хөрсөнд ойр булагдсан онцлогтой ажээ. Зүүнгарын хотгорын нефть, нүүрс, Алтай уулын алт, үнэт чулуу, ховор болон өнгөт төмөрлөгийн баялаг сан юм.

Или казахын өөртөө засах тойргийн нутаг нь усны нөөцөөр нэн арвин ажээ. Энд гол мөрний жилийн урсгалын нийт хэмжээ 40 миллиард м<sup>3</sup>, бүх Синьцзяны усны нөөцийн 41%-ийг эзэлдэг байна. Тойргийн хэмжээнд 66 усан цахилгаан станцтай бөгөөд хүчин чадал нь 3,7 сая квт ажээ. Газрын гүний усны хэмжээ 4,7 миллиард м<sup>3</sup> юм. Иймд тус тойргийн байгалийн нөхцөл нь цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, үйлдвэр хөгжүүлэх, ус ашиглах, усан тээвэр, жуулчлал, хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд бололцоотой юм.

Тойргийн нутаг нь хүйтэн бүсэд, хагас хуурай, эх газрын уур амьсгалтай байна. 3-5 сар цаг агаар нь хүйтэн, хур бороогүй үе нь 140-180 хоног байна. Агаарын жилийн дундаж температур нь 7-8° С, 160 хоног 10°С-ээс дээш, нарны тусгалын хэмжээ 4—9 сард 1728 цаг, жилийн дулаан 3100—2500° С юм. Ийм уур амьсгал нь мал аж ахуй эрхлэхэд ихээхэн таатай боломж олгодог байна.

Или казахын өөртөө засах тойргийн тал нутаг нь үржил шимтэй хүрэн, хар шороотой учир газар тариалан эрхлэх боломж олгодог байна. Тариалангийн талбайн хэмжээ нь 867 мянган га, байгалийн бэлчээрийн хэмжээ 20 сая га бөгөөд бэлчээрийн хувьд Синьцзянд тэргүүлэх байр эзэлж, малаа ихэвчлэн жилийн дөрвөн улиралд бэлчээрээр маллаж байна. Ойн талбайн хэмжээ 746 мянган га, нэлээд хэмжээний мод бэлтгэдэг газар юм. Или Казахстан өөртөө засах тойрог нь дараахь гурван аймгаас бүрдэнэ.

**1. Или аймаг.** 1954 оны 11-р сарын 29-ноос урьд нь Или тусгай район нэртэй байгаад Или казахын өөртөө засах тойрогт харьяалагдсан. 1975 онд Или тусгай район байгуулагджээ. 1979 онд Или тусгай районыг татан буулгаж түүнд харьяалагдаж байсан Кульжда хот,

Кульжда Нылкы, Синьюань Гунлю. Текес хошуу нь Или казахын өөртөө засах тойрогт шууд харьяалагдах болов.

**2. Тарбагатай аймаг.** 1950 онд Тарбагатай тусгай район байгуулав. 1970 онд Тарбагатай тусгай районыг Тарбагатай орон нутгийн район болгон өөрчлөв. 1978 онд Шихэзы орон нутгийн районд байсан Шавань сянийг (хошуу) Тарбагатай орон нутгийн районд харьяалуулав. Тарбагатай аймаг 65 мянган км<sup>2</sup> газар нутагтай. 750 мянган орчим хүнтэй. Голдуу хятад, казах, уйгур, дунган, монголчууд оршин суудаг юм. Эдийн засгийн үндэс мал аж ахуй, түүнд хүн амын 80 орчим хувь ажилладаг. Түүнд одоо Усу, Толи, Юйминь, Эмин. Шавань Тарбагатай хошуу (сянь), 1954 ны 9-р сарын 10-нд байгуулагдсан Ховуг сайр монгол үндэстний өөртөө засах хошуу (сянь) багтана.

**3. Алтай аймаг.** 1954 онд Ашан тусгай районыг Алтай тусгай район болгон өөрчлөв. 1970 онд Алтай тусгай районыг Алтай орон нутгийн район болгожээ. Алтай орон нутгийн районд Алтай, Цинхэ, Фуюнь, Фухай, Жеменай, Бурчум. Хаба зэрэг долоон хошуу (сянь) харьяалагдана. Засаг захиргааны төв нь Алтай хот. Тус аймагт 1979 оны байдлаар 400 мянган хүн оршин сууж байсны 70 орчим хувь нь хятад хүмүүс байв. Бусад олонхи нь казахууд бөгөөд олонхи хэсэг нь хөдөө аж ахуйд ажилладаг юм.

ХКН-ын Төв Хорооны 11 дэх удаагийн Ш бүгд хурлын (1978) дараагаар үндэстний бодлогод гарсан өөрчлөлтийг дагалдан тус өөртөө засах тойргийн нийгэм-эдийн засаг, соёлын амьдралд тодорхой өөрчлөлт гарсан ажээ. Эндхийн хятад биш ард түмний зан заншил, соёлыг хүндэтгэн үзэх болсон байна. Сүүлийн арав гаруй жилд тойргийн эдийн засаг, соёлын амьдралыг шинэчлэн байгуулах ажил хийв. Үүний үр дүнд 1985 онд аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийт өртөг 1,563,210 мянган юань болсон нь 1984 оныхоос 15%, 1980 оноос 69 % өсчээ. Өөртөө засах тойргийн эдийн засгийн үндэс нь хөдөө аж ахуй, аж үйлдвэр юм. Тойргийн нутагт Карамайн нефтийн үйлдвэр, Синьцзяны үйлдвэрлэл барилгын корпусын 4,7,8, 9, 10-р дивизийг тараан байрлуулсан байна.

Хөдөө аж ахуй нь Синьцзяны хүнс, тос, мах, арьс, мод, хөвөн, эмийн ургамал, чихэр, лууван зэргийн үйлдвэрлэлийн гол бүс нутаг юм. Энд казахын ууцан сүүлт хонь, илийн адуу, үхэр үржүүлж, жимс, архи, алим зэрэг нь хятад даяар мэддэг зүйл болжээ. 1985 онд өөртөө засах тойргийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийт өртөг 993 сая 737 мянган юань болж 1980 оноос 50 % өсч байжээ. Хүнсний бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийн хэмжээ 986298 тонн байсан нь тариалсан талбайн хэмжээ 7,8% багассан нөхцөлд гарц нь 3,8% нэмэгджээ. Мөн онд тослог ургамал 112258 тонн болжээ. Синьцзяны мал аж ахуйн гол район бөгөөд таван хошуу мал өсгөнө. 1985 оны эцсээр малын нийт тоо толгой 8 сая 682 мянга болжээ. Малыг малчдад хариуцлагын системээр олгосноор тэдний гэр бүлийн жилийн орлого 1000—2000 юань болжээ.

Тус тойргийн нутаг нь байгалийн баялагийн нөөцөөр Синьцзянд нэгдүгээр байранд ордог. Олдсон ашигт малтмалын олон уурхайг түшиглэн үйлдвэрүүд байгуулан тэдгээрт боловсруулалт хийж байна. Тойргийн аж үйлдвэрийн гол хэсэг нь Карамай, Кульджа, Алтайд төвлөрчээ. Чугучак, Чапчальд уран баяжуулах фабрик, Алтай, Коктогайд ховор металл хайлуулах, олзворлох үйлдвэр уурхай байгаа ажээ. Хотуудад хүнс, саван, тамхи, нэхмэл, гутал зэргийн хөнгөн үйлдвэрүүд байрладаг байна.

Или казахын өөртөө засах тойргийн нутагт БНХАУ-ын нефтийн томоохон үйлдвэрийн нэг-Карамайн нефтийн үйлдвэр юм. 1958 оны

6-р сарын 29-нд тус үйлдвэрийн хот Карамайг байгуулж, СУАР-д харьяалуулсан байна. Карамай нь 4 район, нэг хот, 2 тосгон зэргээс бүрдэнэ. Карамай нь 9500 км<sup>2</sup> газартай, 240 мянган хүнтэй, хүн амын 79 хувь хотод суудаг байна. Карамайн нийт оршин суугчдын 77 хувь нь хятад иргэд бөгөөд тэднээс гадна казах, монгол, хотон монгол, шивэй зэрэг 30 гаруй үндэстний төлөөлөгчид оршин суудаг байна.

Карамайн нефтийн үйлдвэр нь 1955 оны 10-р сараас эхлэн бүтээгдэхүүнээ гаргаж эхэлж, үйлдвэрлэл явуулж байна. 1987 оны байдлаар Карамайн нефтийн үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт хэмжээ 1,35 мил лиард юань болж 5,7 сая тонн нефть гаргаж байгаа. Карамайн орчимд үйлдвэрлэл-барилгын 4 корпус газар тариалан, мал аж ахуй эрхлэн ажилладаг байна. Карамайд радио, телевизийн станц, хиймэл дагуулаас таван сувгаар хүлээн авах станц, 26 кино театр, 53 номын сан, ажилчид, ажилтнуудын амрах газар, биеийн тамир-спортын барилга байгууламж байдаг ажээ.

Или Казахын өөртөө засах тойргийн эдийн засгийн бүтцийг шинэчилснээр аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ өсчээ. 1985 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өртөг нь 1980 оноос 121, 16% өсч, 609,2 сая юаньд хүрсэн байв. Тус тойрогт тээвэр холбоо, их барилгын ажил хөгжиж байна.

БНХАУ-д нээлттэй байх бодлого явуулснаар тус тойргийн гадаад эдийн засгийн харилцаа өргөжив. Хоргос боомтоор хүдэр, хүнс, тэжээл, үр тариа, ноос, бөс бараа болон өргөн хэрэгцээний барааны гаргах хэмжээ жил бүр өсч байна. Зөвлөлт Казахстанас цемент, болд, шилэн эдлэл зэрэг бараа авдаг байна.

Тус тойргийн Алтай аймаг нь манай Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймагтай хилийн худалдаа хийж байна.

Или казахын өөртөө засах тойрогт дээд сургууль 2, техникум 16, техник мэргэжлийн сургууль 4 ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургууль 438-д 176 мянган сурагч, бага сургуульд 399 мянган хүүхэд суралцаж байв. Хятад биш үндэстний хувьд ерөнхий боловсролын салбарт ахиц гарч, голдуу казахууд төвлөрөн суудаг Алтай аймагт 268 бага сургууль, 99 дунд сургууль ажиллаж 30 мянга орчим хүүхэд суралцаж байв. Хөдөө аж ахуй, өнгөт металл, эрүүлийг хамгаалах, багшийн сургууль зэрэг тусгай мэргэжлийн 5 сургууль, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургууль нэг байгаа хийгээд санхүү худалдаа, уран сайхан анги байна.

Олон нийтийн дунд соёл, олон нийтийн ажил идэвхтэй явагдах должээ. Энд уран сайхны чуулга 31, кино үзүүлдэг нэгж 968, тойрогт сонины нэгдсэн 3 редакци, казах хэлний хэвлэлийн хороо ажиллаж байгаа ажээ. Казах хэлээр «Алтай аясында» («Алтайн уянга»), «Тарбагатай», «Или айдыны» («Или мөрөн») гэсэн уран зохиолын 3 сэтгүүл, залуучуудад зориулсан хоёр сэтгүүл гарч байна. Телевиз, радио станц 47 ажиллаж, хүн амын ихэнх хэсэг нь телевиз үзэж байна. Радиогийн казах хэлний нэвтрүүлэг 1955 оноос, телевизийн казах хэлний нэвтрүүлэг 1985 оноос явагдах болов.

Тойрогт биеийн тамир, спортын ажил идэвхжиж, үндэстний онцлогтой бөх, морь, сур харвах зэрэг төрлүүд төрөл бүрийн тэмцээнд орох болов.

Или Казахын өөртөө засах тойрог нь нийгэм-эдийн засаг, соёлын байгуулалтаа хөгжүүлэн 2000 онд аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээг дэхүүний нийт хэмжээг 7,5 миллиард юаньд хүргэхээр зорьж байгаа ажээ. Тэр цагт нэг хүнд оногдох үндэсний орлогын хэмжээ 2400 юаньд хүрч, одоогийнхоос 3 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.